## ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024-2025 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

| № | ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | Хэрэгжилт | Хэрэгжилт хувь |
|---|---|---|---|
| 1 | 1.4.1.1.Орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож улсын төсвөөс, төрийн захиргааны албан хаагчид 80 хувь хүртэл нэмэгдүүлэх эрхийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ | Засгийн газрын 2024 оны 02 дугаар 28-ны өдрийн 82 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөөгийн суманд ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид үндсэн цалингийн 40 хувиар, харин аймгийн төв болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн цалингийн 20 хувиар тооцож олгохоор холбогдох журмыг шинэчлэн батлуулсан.<br><br>Журам батлагдсанаар өмнө нь орон нутгийн нэмэгдэл авдаггүй байсан шинжлэх ухаан зэрэг төрийн мэргэжлийн үйлчилгээний зарим албан хаагчид, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг шинээр авч эхэлсэнээр төрийн үйлчилгээний нийт албан хаагчид орон нутгийн нэмэгдэл авах боломжтой болмон. Мөн улс төрийн албан тушаал эрхэлдэг албан хаагчид уг нэмэгдлийг шинээр авч байна. Уг арга хэмжээнд нийт 105.2 мянган төрийн албан хаагчид хамрагдсан бөгөөд улсын төсвөөс 308.0 тэрбум төгрөг зарцуулсан.<br><br>Мөн тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэх боломжтой болсон.<br><br>2024 онд орон нутгийн төсвөөс олгох нэмэгдлийн хувьд 20 хувиас дээш нэмэгдлийг нийт 14 аймаг олгож байна. Тухайлбал, Говьсүмбэр аймаг 100 хувь, Өмнөговь аймаг 80 хувь, Орхон аймаг 60 хувь, Сэлэнгэ, Ховд аймаг 50 хувь, Баянхонгор, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймаг 40 хувь гэх мэт.<br><br>Сангийн яамнаас 2025 онд орон нутгийн төсвөөс нэмэгдүүлэн олгох нэмэгдлийн мэдээллийг 1 дүгээр сарын цалингийн мэдээлэл төрийн албаны цалингийн нэгдсэн системд бүрэн орсоны дараа буюу 2 дугаар сард гаргах боломжтой гэсэн хариуг өгөөд байна. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| **2.1.1.Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого** | | | |
| 2 | 2.1.1.1.Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ. | Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна” гэж, Мөн зүйлийн 29.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 29.1-д заасан тэтгэврийн нөөц сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж, 29.3.1.энэ хуулийн 18.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого;<br>29.3.2.энэ хуулийн 29.2-т заасан мөнгөжүүлсэн орлогоос бүрдэнэ.<br><br>Мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4.Энэ хуулийн 29.3-т заасан орлогыг даатгуулагч бүрээр хуваарилж, тэтгэврийн нөөц сангийн дансанд байршуулна.<br>29.5.Тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн доор дурдсанаар хөрөнгө оруулж болно:<br>29.5.1.энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд;<br>29.5.2.тухайлсан хуулиар зохицуулсан эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд.<br>29.6.Даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ.<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчлэлийн хүрээнд “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжих, цаашид бүрэн хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих эрх зүйн орчин бүрдсэн. 2024 оноос эхлэн даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц санг үүсгэж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн ажил олгогчийн төлөх 1.0%, даатгуулагчийн төлөх 1.0%, нийт 2.0%, мөн сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын 2.0%-ийн шимтгэлийг хуримтлуулж эхэлсэн. Энэ хүрээнд Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж буй 1.2 сая даатгуулагч бүр бодитоор “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-тай болж нийт 214.8 тэрбум төгрөгийн бодит мөнгөн хуримтлал үүслээ. “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-ын мэдээллийг төрийн үйлчилгээний “E-Mongolia” цахим систем, нийгмийн даатгалын байгууллагын цахим систем portal.ndaatgal.mn болон гар утасны “nDaatgal” аппликейшнээс харах боломжийг бүрдүүлээд байна. | 90 |
| 3 | 2.1.1.2. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлуулахаар 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1208 тоот албан бичгээр хүргүүлэн ХЗДХЯ-наас ирсэн саналыг тусган 2025 оны 01 дүгээр сард дахин батлуулахаар хүргүүлсэн. Мөн хуулийн тандан судалгааны тайлан болон Гэр бүлийг дэмжих тухай хуулийн | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | | төслийг боловсруулж 11 дүгээр сард ажлын хэсгийн төлөөллөөр 3 удаа хэлэлцүүлсэн. Хуулийн төслийг боловсруулах хүрээнд гэр бүлийг дэмжих чиглэлээр олон улсын туршлага, Монгол Улсад хууль тогтоомжийн дагуу олгогдож байгаа дэмжлэгүүдийг нэгтгэн гаргаж, шинээр бий болгох саналыг гарган Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн төлөөллөөр 11 дүгээр сарын 28-ны өдөр хэлэлцүүлэв. Хэлэлцүүлгээс гарсан саналыг хуулийн төсөлд тусган ажиллаж байна. Тус хуулийн төсөлд гэр бүлд цогц төвөөр дамжуулан үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг тусган боловсруулж байна.<br>Гэр бүлийг дэмжих тухай хуульд тусган хэрэгжүүлэхээр, төлөвлөж байна. Мөн Монгол гэр бүлийн харилцааны хэв шинжийн өөрчлөлт 2024 судалгааг ХНХЯСҮСИ-тэй хамтран хийж, 2025 оны 04 дүгээр сард багтаан дуусгахаар ажиллаж байна. Энэхүү судалгаан үр дүнд үндэслэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | |
| 4 | 2.1.1.3.Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | Хиймэл оюун нэвтрүүлэх боломжтой үйлчилгээг тодорхойлох судалгааг хийж шаардлагатай үйлчилгээнд нэвтрүүлэхээр 2025 оны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. | Хугацаа болоогүй |
| 5 | 2.1.1.4.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ | Гэр бүлд суурилсан нийгмийн үйлчилгээг хүн амын бүлгүүдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлж, тэгш хүртээмжтэй, чанартай, хүний эрхэд тулгуурлан цогцоор үзүүлэх” хүрээнд “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв”-ийн загвар төвийг байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлохоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024 оны 08 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд тус Орхон, Хөвсгөл аймагт ажиллан гэр бүлд чиглэсэн үйлчилгээний зураглалаа гаргасан. Эхний ээлжинд Орхон, Хөвсгөл аймагт хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрыг түшиглэн үйлчилгээг туршихаар удирдамжийн төслийг боловсруулж байна<br><br>Улсын хэмжээнд Гэр бүлд зөвлөгөө өгөх 4 төв, 27 танхимаар гэр бүл түүний гишүүдэд чиглэсэн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлж байгаагаас 12,406 иргэнд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, 1,384 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, хөгжлийг дэмжих сургалтуудад 297,375 иргэнийг хамруулан, 11,893 иргэнийг үйлчилгээнд холбон зуучилсан. Үүнээс 216,079 насанд хүрэгч, 52,025 хүүхэд байна. Нийт гэр бүлийн 30.2 хувьд хүрсэн. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 6. | 2.1.1.5.Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ | Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, нэг хүүхдэд ногдох зардлын дундаж норматив, Сум хороонд ажилах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал, орон тоог тус тус батлуулсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын нормативыг мөрдүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд 21 аймаг, нийслэл, дүүргийн хүүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон төрийн сангийн, нийгмийн бодлогын хэлтсийн холбогдох албан хаагчдыг сургах сургалтын төлөвлөгөөг гаргаж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 1 дүгээр сард УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан бөгөөд тус хуульд хүүхэд хамгааллын аюулгүй орчны зохицуулалтыг шинээр нэмж, анхан шатны нэгжид буюу сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулахаар зохицуулсан. Энэ хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал, нийгмийн ажилтны орон тоог батлах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж, батлуулсан бөгөөд орон нутагт 590, нийслэлд 337, улсын хэмжээнд нийт 833 хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан сум, хорооны түвшинд анх удаа ажиллана.<br>Хүүхэд хамгааллын тухай хуулийн 58.2-д заасны дагуу сум, хорооны хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнууд 2025 оны 1-р сараас эхлэн ажиллаж байна.<br>Ингэснээр гэр бүл дэх хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, аюулгүй амьдрах орчин бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ | 90 |
| 7. | 2.1.1.6.Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна. | Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан Хүүхэд хамгааллын бодлогыг Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Хүүхдийн эрхийн тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна. 2025 оны 1 дүгээр улиралд батлуулж, олон нийтэд түгээх сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулна. Мөн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээнд тусган батлуулсан.<br>- “Хүүхэд хамгааллын бодлого”-оо баталсан 9 яам, 3744 байгууллага, аж ахуйн нэгж, “Эцэг эхийн зөвлөл”-өө байгуулсан 7050 байгууллага, аж ахуйн нэгж, 629 байгууллага хүүхдийн өрөө тохижуулж, 75 байгууллага дэргэдээ хүүхдийн цэцэрлэг байгуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасны дагуу Хүүхэд хамгааллын бодлогыг шинэчлэн батлуулж, 2025 оны 2-р улиралд арга ззйн сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>. | 90 |
| 8. | 2.1.1.7.Сум, хороо бүрд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, | Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 1 дүгээр сард УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан бөгөөд тус хуульд хүүхэд хамгааллын аюулгүй орчны зохицуулалтыг шинээр нэмж, анхан шатны нэгжид буюу сум, хороо бүрд | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ | хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулахаар зохицуулсан. Энэ хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлал, нийгмийн ажилтны орон тоог батлах тухай тогтоолын төслийг хэлэлцүүлж, батлуулсан бөгөөд орон нутагт 590, нийслэлд 337, улсын хэмжээнд нийт 833 хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан сум, хорооны түвшинд анх удаа ажиллана.<br>Хүүхэд хамгааллын тухай хуулийн 58.2-д заасны дагуу сум, хорооны хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтнууд 2025 оны 1-р сараас эхлэн ажиллана.<br>Ингэснээр гэр бүл дэх хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, аюулгүй амьдрах орчин бүрдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.<br>Хүүхэд хамгааллын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.16-д заасан “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах мэргэшүүлэх хөтөлбөр, журам”-ыг 2024 оны 12 дугаар сард баталсан бөгөөд анхан шатанд, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх эдгээр нийгмийн ажилтанд мэргэжлийн мэдлэг, практик ур чадвар олгохоор дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байна. Үүнд:<br>1. Нийгмийн ажил, үйлчилгээний онол, сэтгэл судлал болон холбогдох хууль эрх зүйн мэдлэг олгох “Нийгмийн ажлын кэйс менежмент” сургагч багшийн болон суралцагчийн гарын авлагын багц, сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, хэвлүүлэхэд бэлтгэн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газарт хүлээлгэн өгсөн. Уг сургалтын хөтөлбөр, модуль нь сум, хороонд ажиллаж эхлэх хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны зайлшгүй мэдэх шаардлагатай 4 багц модулийг агуулсан бөгөөд цаашид цахим болгож, орон нутгийн албан хаагчдын сургалт, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор цахимжуулах шаардлагатай.<br>2. Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны жишиг албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсныг Төрийн албаны салбар зөвлөл дэмжсэнээр, ХГБХХЕГ-ын даргын тушаалаар батлагдсан.<br>3. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын тушаалаар Сум, хороонд ажилллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг сургаж чадавхжуулах зорилгоор анхан шатны нийгмийн ажилтныг “чиглүүлэх, мэргэшүүлэх” сургалтыг 2025 оны 1 дүгээр сарын 21-28-ны хооронд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулахаар удирдамж, хөтөлбөр батлаж, төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.<br>Дараагийн шатны ур чадварын сургалтыг 2025 оны 2-3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.<br>Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний стандарты н төслийг боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газрын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ТХ-46 | |

| | | | |
|---|---|---|---|
| | | стандартын техникийн хороогоор хэлэлцүүлж, дэмжигдсэн. Стандартыг 2025 оны 1-р улиралд дахин хэлэлцүүлж, батлуулахаар ажиллаж байна. | |
| 9 | 2.1.1.8.Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтална. | Хэрэгжиж эхлээгүй | Хугацаа болоогүй |
| 10 | 2.1.1.11."Цалинтай эх, эцэг" нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно. | Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд<br>0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэгт олгодог "Цалинтай эх, эцэг"-ийн тэтгэмжид 2024 оны 12 дугаар сарын байдлаар 172,109 хүн хамрагдаж, 73,212,439.0 төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Мөн Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлд туссан. Хуулийн төслийг боловсруулж байна. | Хугацаа болоогүй |
| 11 | 2.1.1.12.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ. | Хэрэгжилт эхлээгүй, төлөвлөлтийн шатанд | Хугацаа болоогүй |
| 12 | 2.1.1.13.Эхчүүдэдзориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ. | Монгол гэр бүлийн харилцааны хэв шинжийн судалгааг эхлүүлсэн бөгөөд 2025 оны 04 сард багтаан дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. Энэхүү судалгааны үр дүнд гэр бүлийн цогц үйлчилгээний төвд хүн амын бүлэг тус бүрээр үзүүлэх үйлчилгээний хөтөлбөрийг боловсруулна. | Хугацаа болоогүй |
| 13 | 2.1.1.15.Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр дамжуулан эрэгтэйчүүдэд зориулсан хөгжлийн болон нийгмийн үйлчилгээг үзүүлнэ. | Эрэгтэйчүүдэд чиглэсэн нийгэм, сэтгэл зүйн цогц үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн үйлчилгээний арга зүй боловсруулж, гарын авлага гаргасан. Энэхүү арга зүйн гарын авлагын дагуу 21 аймаг, 9 дүүрэгт сургагч багш бэлтгэсэн. Түүнчлэн олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх жишиг төв”-ийг нийслэлийн Чингэлтэй дүүрэгт анх удаа байгуулж, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн 6 сарын хугацаанд 146 хүнд утсаар зөвлөгөө, 85 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, 44 хүн буюу 22 гэр бүлийн гишүүдэд хосын зөвлөгөө, 23 подкаст, 23 төрлийн сургалт, сурталчилгаа, 2334 удаагийн цахим сурталчилгаа, цахим хуудсаар дамжуулж 253 хүнд зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн. | 70 |
| 14 | 2.1.1.16.Эрэгтэйчүүдийн зонхилон ажилладаг салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 16-ны А/74 дугаар тушаалаар байгуулсан. Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг доктор | 70 |

Д.Нарансүх хийж гүйцэтгэн, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуулийн тандан судалгааны дүнг танилцуулсан бөгөөд биелэлт дүгнэлтийг хүлээн авсан.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 12 дугаар сарын 16-ны А/74 дугаар тушаалаар байгуулсан. Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын дэмжлэгтэйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг доктор Д.Нарансүх хийж гүйцэтгэн, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хуулийн тандан судалгааны дүнг танилцуулсан бөгөөд биелэлт дүгнэлтийг хүлээн авсан.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас тус журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6518 дугаарт бүртгэсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд бүртгэлтэй MNS ISO 17020 стандартын итгэмжлэлтэй, дараах 6 байгууллага ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв
2. “Түмэн тэрэм” ХХК
3. “Хэлт инспекшин” ХХК
4. “Эв ихт глюк” ХХК
5. “Хэлт сэфти энд фрий воркплэйсэс” ХХК
6. “Даблью эйч эс” ХХК

Дээрх байгууллагууд 2024 онд 275 аж ахуйн нэгж, байгууллагын 4686 ажлын байранд хэмжилт үнэлгээ хийж, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах тухай зөвлөмжийг хүргүүлж ажилласан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хэмждэг хоёр гол үзүүлэлт бол үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тоо, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо юм.

***Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого***

- ***2024** онд **улсын хэмжээнд*** нийт **712** үйлдвэрлэлийн осол гарснаас **547 эрэгтэй**, нийт ***87*** хүн нас барсан байна.

Нийт ослын ихэнх хувийг уул уурхай болон барилгын салбар эзэлж байна.

***Мэргэжлээс 1 шалтгаалах өвчин***

| | | | |
|---|---|---|---|
| | | - ***2024*** онд МШӨ-ний тэтгэвэр авдаг хүний тоо **2273** байгаагаас эрэгтэй **1860** хүн байна. Үүнээс **36** хүн нас барсан байна .<br><br>- ***2023*** оны нийт **2593** хүн мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан байгааг харахад энэ онд буурсан үзүүлэлттэй байна.<br><br>2024 онд идэвхтэй хяналтад байдаг өвчтөнийг салбараар нь авч үзвэл уул уурхай, олборлолтын салбарт **1729,** барилга **266** иргэн тус тус байна. | |
| 15 | 2.1.1.18.Ахмад настанд Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр дамжуулан тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжинэ. | Азийн хөгжлийн банктай хамтран Олон нийтийн оролцоонд түшиглсэн ахмад настны урт хугацааны шинэлэг тогтолцоог хөгжүүлэх нь төслийн хүрээнд Идэвхтэй насжилтыг дэмжих төвийг 3 газар туршсан. Энэ хүрээнд Аймгийн төвийн, сумын түвшинд, дүүргийн түвшинд 3 чиглэлээр Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн загварыг бий болгосон. Дээрх загварыг Азийн хөгжлийн банктай хамтран 7 төв дээр сургалтын загвар төв болгон ажиллахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>Улсын хэмжээнд 500 гаруй ахмадын ордон, өргөө, төв, танхимаар 2024 оны байдлаар 324,000 ахмад настан буюу 84 хувь хамрагдаж соёл, спорт, соён гэгээрүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээнд хамрагдсан байна. | 90 |
| 16 | 2.1.1.19.Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэйгөөс бусад ажлын байранд ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна. | Хууль хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/106 тоот албан бичгээр төрийн жинхэнэ алба болон төрийн үйлчилгээний албан тушаалд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг авч ажиллуулсан тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасан нэмэгдлүүдийг олгох эсэх, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Өндөр насны тэтгэвэртэй холбогдох зарим асуудлын тухай” 07 дугаар зөвлөмж хүчинтэй эсэх, хүчинтэй тохиолдолд тус зөвлөмжийн 8 дахь хэсгийг хэрхэн тайлбарлах талаар зөвлөмж хүсч, хамтран ажиллах санал хүргүүлэв. | 100 |
| 17 | 2.1.1.20.Ахмад настныг шинэ ур чадварт сургах, ажил, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр-2025-д Ахмад настны дэмжих арга хэмжээг оруулж төслийг боловсруулж ХЭҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. | Хугацаа болоогүй |

| | | | |
|---|---|---|---|
| 18 | 2.1.1.21.Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ. | Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдуулж Нийгмийн халамжийн тухай хуулийн 19.11, 19.12 дахь хэсэгт ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлж болох ба дэмжлэгийн хэлбэр, хэмжээ, олгох журмыг Засгийн газар батлахаар заасан.<br><br>Үүний дагуу "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулан яамдын саналыг авч тусган Засгийн газрын тогтоолыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.<br><br>Уг журмаар ахмад настанд төрөлжсөн асрамжийн үйлчилгээг 20 ба түүнээс дээш тооны асруулагчид 12 сараас дээш хугацаагаар үзүүлж байгаа бол нэг удаа 100.0 хүртэл сая төгрөгийн түрээсийн зардлын дэмжлэг, 50-аас багагүй тооны асруулагч хүлээн авах хүчин чадалтай төрөлжсөн асрамжийн газрын барилга байгууламж шинээр барих аж ахуйн нэгж, байгууллагад барилгын ажлын гүйцэтгэл нь 50-аас дээш хувьд хүрсэн бол нэг удаа 500.0 хүртэл сая төгрөгийн зардлын дэмжлэг олгохоор тусгасан.<br><br>Дэмжлэгийн зардлыг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангийн асрамжийн үйлчилгээний зардалд тусган хэрэгжүүлэх юм.<br><br>Ингэснээр төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг хувийн асрамжийн газар байгуулахад хөрөнгө санхүүгийн хувьд дэмжихээс гадна тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие ахмад настанд үзүүлэх асрамжийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх юм.<br>Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1-д заасныг үндэслэн "Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/76,515 тоот хамтарсан тушаалаар батлан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.<br><br>Уг журмаар ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлох цогц үнэлгээ хийж, тулгамдсан асуудлыг эрэмбэлэн тогтоож, хэрэгцээнд суурилсан цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх, хяналт тавих асуудлыг хэрэгжүүлэхээр тусгасан.<br><br>Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж, үйлчилгээ үзүүлэх журам нь Нийтлэг үндэслэл, Ахмад настны цогц тусламж, үйлчилгээнд баримтлах зарчим, ахмад настны цогц үнэлгээ хийх, Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, Идэвхтэй насжилтыг | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | дэмжих төвийн үйлчилгээ, Асаргааны хувилбарт үйлчилгээ, Ахмад настанд үзүүлэх өдрөөр эмчлэх, сувилах үйлчилгээ, Ахмад настанд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ, Ахмад настны цогц тусламж үйлчилгээнд тавих хяналт, тайлагналт гэсэн нийт 9 зүйлтэй .<br><br>Ахмад настны цогц үнэлгээгээр 1 дүгээр түвшин, мөн 2 дугаар түвшний зарим ахмад настанд Идэвхтэй насжилтыг дэмжих төв, Ахмадын ордон, өргөөгөөр Ахмад настны тухай хуулийн 7.1.1-7.1.5, 7.1.9-д заасан үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх, мөн үнэлгээгээр 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшний ахмад настанд Асаргааны хувилбарт үйлчилгээг журамд заасан төрөл, хэлбэрээр үзүүлэх юм.<br><br>Мөн эрүүл мэндийн байгууллагаар, Эрүүл мэндийн даатгалын сангийн хөнгөлөлтөөр ахмад настны Өдрөөр эмчлэх, сувилах үйлчилгээ, Сэргээн засах үйлчилгээг үзүүлэхийг журамд заасан.<br><br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/75, 514 тоотхамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх иргэн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг баталсан.<br><br>Уг журмаар ахмад настанд Идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ, асаргааны хувилбарт үйлчилгээний төрөл болох гэрээр асрах, өдрөөр асрах, гэрээр асрах, түр болон урт хугацаагаар асрах, байнга асрах, төрөлжсөн асрамжийн үйлчилгээ зэргийг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулахтай холбоотой харилцааг зохицуулах юм.<br><br>Ингэхдээ иргэн, аж ахуйн нэгж, байгуулллагыг сонгон Ахмад настны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хэрэгжүүлэх ба уг хуулийн 15, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлагыг тусгасан болно. | |
| 19 | 2.1.1.22.Тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 540 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 650 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн. Түүнчлэн УИХ-аас Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд хуульд тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оноос эхлэн жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлэх зохицуулалт тусгаж нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийн хэмжээг | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлж, Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн тэтгэврийн доод хэмжээг 689,000 (зургаан зуун наян есөн мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572,400 (таван зуун далан хоёр мянга дөрвөн зуу) төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн.<br>Нийгмийн халамжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тухайн үед мөрдөж байгаа хүн амын амьжиргааны доод түвшингийн хэмжээг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэж заасан.<br>Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг цар тахлын үед нэмэгдүүлсэн 288 мянган төгрөгөөр олгохоор “Тогтоолд өөрчлөлд оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Засгийн газрын 2023 оны 3 дугаар тогтоолоор батлуулав. Ингэснээр нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 288 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож, 70 мянга гаруй зорилтот бүлгийн иргэдийн нийгмийн баталгааг хангах боломж бүрдсэн. Мөн Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн 325 мянган төгрөг болгон нэмэгдүүлэн тогтоосон. 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 15.4 хувь буюу 50 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 375 мянган төгрөгөөр тогтоон олгосон бөгөөд Монгол Улсын 2024 оны төсөвт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 60.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг баталсан. Мөн 2025 онд нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлж 397.5 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бэрхшээлийн ангилал, ялгаатай онцлог хэрэгцээг харгалзан байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг 445 мянган төгрөгт хүргэн тус тус нэмэгдүүлэхээр 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэж, Засгийн газрын 247 дугаар тогтоол гарсан. | |
| 20 | 2.1.1.23.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулна. | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөлд ойлголт, хандлага төлөвшүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах асуудлыг тусган боловсруулаад байна.<br>Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд 2024 онд “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-ыг 34 удаа зохион байгуулж, 3000 гаруй хүнийг хамруулсан байна.<br>Хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх хүрээнд “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт”-ыг 34 удаа зохион байгуулж, 3000 гаруй хүнийг хамруулсан байна. | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран “Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгч болон ганц бие иргэнийг асран хамгаалж байгаа иргэдэд” чиглэсэн бүлгийн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 30 гэр бүлийн төлөөлөл оролцсон.<br><br>Асрамж, халамжийн байгууллага, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд хэвтэн эмчлүүлж буй 40 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхэд Хүүхэд хамгааллын тухай хуулийн танилцуулга, хүүхэд хүмүүжлийн эерэг аргын сургалт, өдөрлөгийг зохион байгуулсан. | |
| 20 | 2.1.1.24.Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллага, бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ. | Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн төслийг төр, төрийн бус байгууллагад нийт 9 удаа хэлэлцүүлж, ирсэн саналыг тусган ажилласан. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн үзэл баримтлалыг 2024 оны 05 дугаар сард ХЗДХ-ийн сайдтай хамтран батлуулсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн “32.4. Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно” гэж заасан тул хуулийн төслийг дахин боловсруулж байна. Хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандан судалгааг эцэслэн боловсруулсан. Мөн хуулийг дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байна. Хуулийн төсөл 6 бүлэг 23 заалттай бөгөөд Барилга байгууламжийн хүртээмж, зам, замын байгууламж, нийтийн тээврийн хүртээмж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн хүртээмж, үйлчилгээний хүртээмж гэсэн 4 чиглэлээр хүртээмжийн харилцааг зохицуулна<br>Мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр 2021-2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>2022 онд доор дурдсан 16 цахим хуудсанд үнэлгээ хийсэн нь бүгд хүртээмжтэй байдлын шаардлагад нийцээгүй, шалгуур хангасан үзүүлэлт байхгүй байна. Үүнд:<br>1. ХБХХЕГ gadpwd.gov.mn<br>2. Худалдаа хөгжлийн банк tdbm.mn<br>3. Номин супермаркет eshop.nomin.mn<br>4. Е-баримт ebarimt.mn<br>5. Look TV looktv.mn<br>6. Ikon news ikon.mn<br>7. Unread news unread.mn<br>8. Халамжийн нэгдсэн систем ehalamj.mn<br>9. Өргөө кинотеатр urguu.mn<br>10. Zindaa.mn | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 11. Livetv.mn<br>12. Zarig.mn<br>13. News.mn<br>14. Montsame.mn<br>15. Gogo.mn<br>16. Dnn.mn<br>Мөн И-Монголиа академи УТҮГ-тай хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй хүн И-Монголиа системд нэвтэрч төрийн үйлчилгээг хүртээмжтэй авах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. **Харааны бэрхшээлтэй, сул хараатай, гэрэлд мэдрэг, сурахад хэт мэдрэг зэрэг хүнд зориулсан тусгай хүртээмжийн тохиргоог гар утсанд суулгах И-Монголиа аппликейшнд нэвтрүүлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэх авах цэс нэмж оруулсан.** 2022 онд ХБХХЕГ-аас ЦХХЯ, И-Монголиа академийн ажилтнуудад хөгжлийн бэрхшээлийн ойлголт хандлагын хичээл ордог байсан бол 2023 онд И-Монголиа академи нь 308 хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцаж тэдэнд аппликейшн хэрхэн хэрэглэх сургалт оруулсан бөгөөд Хурдан үйлчилгээ нэвтрүүлж ТҮЦ үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэрэгтэй үйлчилгээг хүргэн ажиллаж байна.<br><br>МУИС-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Ярьдаг, сонсдог номын сан ашиглалтанд оруулсан, бичдэг үзэг, томруулагч, компьютерт сурилуулсан апп болон брайль төхөөрөмж, дэлгэц зэргийн тусламжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд хүртээмжтэй орчинд хичээл давтах өрөө, номын сантай болсон.<br><br>Мөн байгууллага тус бүрээс 3 нийт 33 хүнд үнэлгээ хийх арга, аргачлал, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчныг бүрдүүлэх талаарх сургалтыг танхим болон цахимаар 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Үнэлгээнээс гарсан тайланг боловсруулж, зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.<br>**<u>Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</u>** 2021-2024 онд “Түгээмэл хөгжил төв” ТББ, “Эрчис тэргэнцэр засвар зөвлөгөө мэдээллийн төв” ТББ-тай хамтран нийслэлийн 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Архангай, Хэнтий аймгуудын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын 11 газар, ЧД-ийн ерөнхий боловсролын 17, 23, 37, 49, 65, 72, 76, 107, 138, 149, 153 дугаар сургуулиудын нийт 22 барилга байгууламжид хүртээмжийн үнэлгээг хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br><br>Зөвлөмжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурч боловсрох, спортоор хичээллэхэд барилга байгууламжийн дэд бүтцийг MNS 6055:2009, MNS 6808:2019 стандартын | |

| | | | |
|---|---|---|---|
| | | шаардлагын дагуу төлөвлөх, гадна хаяг, орц гарц, налуу зам, үүдний босго, бариул, гэрэлтүүлэг зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх, байгууллагуудын багш ажилтан албан хаагчид дохионы хэлний мэдлэгтэй байх, туслах ажилтан ажиллуулах зэрэг шаардлагатайг тусгасан.<br><br>Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 14 газрын дараах байршлуудад явган хүний зам талбайн дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээг MNS 6055:2009, MNS 6808:2019 стандартын дагуу хийж ажилласан байна.Үүнд:<br><br>- Төв шуудан<br>- Цэцэг төв<br>- Монгол банк<br>- Монголын ипотекийн корпорац<br>- Үндэсний түүхийн музей<br>- Цаг уур орчны шинжилгээний газар<br>- Нийслэлийн Засаг Захиргааны 4 дүгээр байр<br>- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг<br>- Үндэсний түүхийн музей<br>- Чингис хаан музей<br>- Нэгдүгээр дэлгүүрийн уулзвар<br>- СУИС-ийн уулзвар<br>- Монголын хүүхдийн ордон<br>- Спортын төв ордон зэрэг газрууд хамрагдсан ба үнэлгээний тайланг үндэслэн зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлсэн. | |
| 21 | 2.1.1.25.Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана. | АХБ-ны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд “Үйлдлийн олон улсын ангилал /ICF/”-ыг нэвтрүүлэх чиглэлээр Монгол Улсад хэрэгжүүлэхэд тохиромжтой сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлага, аргачлалыг 2023 онд боловсруулан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадварыг /ICF/-д суурилсан үнэлгээг турших сургалт”-ыг нийслэлийн 6 дүүрэг, 8 аймгийн зохион байгуулсан. Сургалтад ЭХМСК-ын магадлагч эмч, аймгуудын Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын, Нийгмийн халамжийн хэлтсийн дарга нарыг хамруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгон 2023 онд туршилтын үнэлгээ хийсэн.<br><br>Түүнчлэн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 28-ны өдөр хүртэл “Үйлдлийн олон улсын ангилал”-д суурилан хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрлөх чадварт үнэлгээ хийх арга хэрэгсэл сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад 6 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн албан хаагчид, | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | | Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын албан хаагчид болон аймаг, дүүргүүдийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн магадлагч эмч нар нийт 70 орчим хүнийг хамруулсан.<br><br>Мөн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох "Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ҮАОУА)-ын талаарх талуудын уулзалт, хэлэлцүүлэг"-ийг 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгууллаа.<br>Тус хэлэлцүүлгийн үеэр Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын танилцуулга, Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын талаар зарим оронд хэрэгжүүлж буй байдал, Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллын цөм иж бүрдлийн талаарх танилцуулга, Эрүүл мэндийн салбарт Олон Улсын хөгжлийн бэрхшээлийн ангилал (ICD-11)-ыг нэвтрүүлж байгаа талаарх мэдээлэл, АХБ-ны "Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хийсэн "Үйл ажиллагаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангиллыг нэвтрүүлэх, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийг чадавхжуулах" зөвлөх үйлчилгээний мэдээллийг тус тус танилцуулж, Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулсан.<br>Хэлэлцүүлгийн гол зорилго нь ICF ангиллыг нэвтрүүлэхийн тулд аль салбарт хэн хариуцах, эхний байдлаар ямар чиглэлд нэвтрүүлэн туршилтын байдлаар хэрэгжүүлэх, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр гэсэн 3 салбарыг хэрхэн холбож ажиллах зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор уг хэлэлцүүлгийг зохион байгуулсан | |
| 22 | 2.1.1.26.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна. | Азийн хөгжлийн банкны "Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах" төслийн хүрээнд Архангай, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Дорнод, Ховд аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг байгуулахаар төлөвлөсөн. Үүний дагуу төвийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/159 дүгээр тушаалаар баталж, Дархан-Уул, Хөвсгөл, Дундговь, Ховд аймгийн ХБХТ-ийн барилгыг 2023 оны 9 дүгээр сард, Дорнод аймгийн төвийг 2024 оны 06 дугаар сард хүлээн авч төвийн үйл ажиллагааг бүрэн эхлүүлээд байна. Архангай аймагт баригдаж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв"-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 65 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд гүйцэтгэгч ЖАМ ХХК болон Мотоблок ХХК-тай байгуулсан гэрээний хугацаа дууссан тул гэрээг дүгнэж, үлдэгдэл ажлын тооцоог хийж, шинээр сонгон шалгаруулалт хийх бэлтгэл ажлыг хангаж байна. | 100 |
| 23 | 2.1.1.27.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 4 хувиас | Нийгмийн даатгалын ерөнхий газраас 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийг авч нэгтгэн боловсруулсан. Нийт 53,756 ААНБ-д 845,635 хүн ажиллаж | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна. | байгаас 19,670 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байна. Ажиллавал зохих хөгжлийн бэрхшээлтэй иргэн 33825 байх бөгөөд хуулийн хэрэгжилт 58%-тай байна.<br><br>Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар ажил олгогч 31 ААНБ-д сурталчлан нийт 59 ажлын байрны захиалга авч, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ААНБ, ТББ-ын бий болгосон ажлын байранд 92 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажлын байрны дадлагажуулагчаар дамжуулан 11 ХБИ-ийг зуучилсан.<br><br>Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2 дах хэсгийн хэрэгжилтэд Төрийн захиргааны төв байгууллага болон топ 100 аж ахуйн нэгж, байгууллагад дүн шинжилгээ хийж хэлэлцүүлсэн.<br><br>Мөн Салбарын хяналтын газраас Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.3 дахь заалтын хэрэгжилтийг хангах чиглэлээр 2024 онд хөдөлмөрийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт 859, төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалт 729 нийт 1586 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулбал зохих орон тоо тутамд ажиллуулаагүй ажлын байрны төлбөрийг төлөөгүй 59 аж ахуйн нэгж байгууллагад 957378,7 мянган төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нөхөн төлүүлэхээр улсын ахлах байцаагчийн акт тогтоосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 53 аж ахуйн нэгж, байгууллага 845276,7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. | |
| 24 | 2.1.1.28.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаж, цахимаар, зайнаас, цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ. | 2024 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар 6 төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан.<br><br>Эдгээр төрийн бус байгууллагууд 300 аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2 дах хэсгийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан.<br><br>Мөн хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор статистик мэдээллийн маягтыг боловсруулан ажиллаж байна.<br>Энэ онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөо эрхлэлтийн хэрэгцээг үнэлэх судалгааг улсын хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөж байна.<br>Судалгааны үр дүнд үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг цахимаар, зайнаас, цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэхүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллана. | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | | Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, нөлөөллийн сургалтыг төр, хувийн хэвшлийн 22 байгууллагын 762 хүнд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт хандлагыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br><br>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2024 онд нийт 2569 иргэн хамрагдаж, 798 иргэн ажлын байраар хангагдаж, 7,509,826,187 төгрөгийг зарцуулсан. Үүнээс:<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд 6 иргэн хамрагдаж, 135,002,997 төгрөгийг;<br>• Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 2205 иргэн хамрагдаж, 777 иргэн ажлын байраар хангагдаж, 5,743,884,200 төгрөгийг;<br>• Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 304 иргэн хамрагдаж, 67,881,400 төгрөгийг;<br>• Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэгийн үйл ажиллагаанд 33 иргэн хамрагдаж, 54,129,500 төгрөгийг<br>• Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 21 иргэн хамрагдаж, 21 иргэн ажлын байраар хангагдаж, 145,690,000 төгрөгийг;<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 1,363,238,090 тус тус зарцуулсан байна. | |
| 25 | 2.1.1.29.Төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулна | Нийгмийн халамжийн тэтгэвэр болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 2020 онд 100.0 мянган төгрөгөөр, 2023 онд 12.8 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Мөн энэхүү тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 15.4 хувь буюу 50.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 375.0 мянган төгрөг болгоод байна. Тэтгэвэр, мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2019 (174.0 мянган төгрөг) онтой харьцуулахад 2.1 дахин нэмэгдүүлсэн. | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | | Харин ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэний тэтгэмж 2020 онд 84.5 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэний тэтгэмж 123.1 мянган төгрөг байсныг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2-3 дахин нэмэгдүүлж 275.0 мянган төгрөг болгосон. Энэхүү тэтгэмжийг мөн 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 хувь нэмэгдүүлж 302.5 мянган төгрөгт хүргэсэн. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар буюу сард 397 500 төгрөгөөр, асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 302 500 (гурван зуун хоёр мянга таван зуу) төгрөгөөр, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.4-т заасан байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг 30 хувиар буюу сард 445 000 төгрөгөөр тус тус тогтоохоор Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн. | |
